



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ 8 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo>
цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад
танилцуулга, мэдээтэй танилцана уу.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2024 он | №8

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл: 1,572.3 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал өмнөх оны мөн үеэс 245.9 тэрбум төгрөгөөр өссөн бол, төлөвлөсөн дүнгээс 3,712.5 тэрбум төгрөгөөр буурчээ.

Төсвийн орлогын хувьд: 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 18,890.5 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 531.1 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн бол өмнөх оны мөн үеэс 4,281.5 тэрбум төгрөг буюу 29.3 хувиар нэмэгдсэн байна.

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 97.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 531.1 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь татварын орлого 2.0 хувь буюу 370.5 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 12.3 хувь буюу 160.6 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэнтэй холбоотой байна.
- Тайлант хугацаанд нийгмийн даатгалын орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого болон бусад татвар, төлбөр хураамжаас бусад төрлийн татварын орлого 3.1-12.6 хувиар төлөвлөснөөс илүү биелсэн гүйцэтгэлтэй гарсан байна.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 160.6 тэрбум төгрөгөөр дутуу биелснээр 87.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь хүүгийн орлого, торгуулийн орлого, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого, болон түрээсийн орлогоос бусад төрлийн татварын бус орлого төлөвлөснөөс дутуу биелсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 17,318.2 тэрбум төгрөгт хүрч 4,243.6 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 80.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 19.7 хувиар дутуу зарцуулагдсан ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.4 хувиар буюу 4,527.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 77.9 тэрбум төгрөгөөр өссөн бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 143.7 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2024 онд нийт 3,359.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 885.4 тэрбум төгрөгийг зарцуулж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ 8 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,572.3 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 эхний 8 сарын гүйцэтгэлээр 18,890.5 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 17,318.2 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,572.3 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 245.9 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөсөн дүнгээс 3,712.5 тэрбум төгрөгөөр буурчээ.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 29.3 хувиар буюу 4,281.5 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 35.4 хувь буюу 4,527.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 6.1 пунктээр их гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 245.9 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөгөөр

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	ӨО-ны мөн үед	2024 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь.	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,365.5	-2,871.2	1,209.6	-42.1	4,080.8
Засгийн газрын бонд	763.5	1,423.4	710.5	49.9	-712.8
Засгийн газрын зээл	-310.1	-690.7	-347.7	50.3	343.0
Өмч хувьчлал	-0.7	-1.6	-0.1	6.9	1.5
НИЙТ ДҮН	1,818.2	-2,140.1	1,572.3	-73.5	3,712.5

Эх сурвалж: Сангийн яам

2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 858.2 тэрбум төгрөг төлсөн бол 1,205.9 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 137.5 тэрбум төгрөг, гадаад бондын үндсэн төлбөрт 573.0 тэрбум төгрөг төлсөн бол гадаад бонд шинээр гаргаагүй байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

“ Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 18,890.5 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 29.3 хувь буюу 4,281.5 тэрбум төгрөгөөр, орлогын төлөвлөгөө 2.7 хувь буюу 531.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл орон нутгийн төсөв 8.7 хувь буюу 389.9 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 2.1 хувь буюу 28.7 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 1.9 хувь буюу 71.4 тэрбум төгрөгөөр, улсын төсөв 3.1 хувь буюу 416.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

” Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 32.3 хувь буюу 330.9 тэрбум төгрөгөөр, улсын төсөв 28.3 хувь буюу 2,851.4 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 43.3 хувь буюу 1,125.0 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 50.4 хувь буюу 1,371.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлогын 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Тэрбум төгрөгөөр

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	14,404.3	13,927.5	4,485.1	4,095.2	3,795.8	3,724.4	1,383.4	1,354.7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	311.0	340.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	13,354.1	12,937.7	4,485.1	4,095.2	3,795.8	3,724.4	1,383.4	1,354.7
Татварын орлого	11,692.0	11,637.0	3,488.1	3,241.4	2,750.6	2,679.2	1,383.4	1,354.7
Орлогын албан татвар	2,736.5	3,295.4	2,817.6	2,669.7	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	2,750.6	2,679.2	1,383.4	1,354.7
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	262.2	270.5	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,904.2	3,755.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	642.6	723.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	18.5	17.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	1,210.8	1,143.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	3,179.3	2,701.8	408.2	301.2	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	1,662.1	1,300.7	997.0	853.8	1,045.2	1,045.2	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	606.6	638.4	383.2	264.4	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	11.9	4.3	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	292.8	240.5	16.4	4.3	1,045.2	1,045.2	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	762.7	421.8	585.5	580.9	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 93.9 хувийг татварын орлого, 6.1 хувийг татварын бус орлого эзэлж байна.

“


Татварын орлого 17,743.0 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө 2.0 хувь буюу 370.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

”

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 29.9 хувь буюу 4,084.5 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 20.7 хувь буюу 197.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Татварын орлогын 33,6 хувийг орлогын албан татвар, 16,1 хувийг нийгмийн даатгалын орлого, 1,5 хувийг хөрөнгийн албан татвар, 21,2 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 4,1 хувийг онцгой албан татвар, 0,1 хувийг тусгай зориулалтын орлого, 6,4 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 16,9 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /Тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд татварын орлого төлөвлөснөөс 2.0 хувь буюу 370.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 3.8 хувиар (149.2 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 2.3 хувиар (68.8 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр хураамж 16.3 хувиар (584.6 тэрбум төгрөг) төлөвлөснөөс дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр татварын орлого 29.9 хувь буюу 4,084.5 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 57.3 хувь (2,174.0 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 28.1 хувь (823.7 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 22.4 хувь (209.4 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 19.8 хувь (474.1 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 19.0 хувь (43.2 тэрбум төгрөг)-иар тус тус өссөн нь нөлөөлжээ.

“


Татварын бус орлого 1,147.5 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 197.0 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 160.6 тэрбум төгрөг буюу 12.3 хувиар буурсан байна.

”

Төлөвлөгөөтэй харьцуулахад хүүгийн орлого 25.4 тэрбум төгрөгөөр, торгуулийн орлого 16.8 тэрбум төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 87.1 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Харин газрын тосны орлого 44.9 тэрбум төгрөгөөр, навигацйин орлого 80.5 тэрбум төгрөгөөр, хувьцааны ногдол ашиг 80.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц /Хувиар/



Татварын бус орлогын 78.7 хувийг нийтлэг татварын бус орлого, 20.9 хувийг тусламжийн орлого, 0.4 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна.

Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 11.1 хувийг хүүгийн орлого, 13.5 хувийг торгуулийн орлого, 14.5 хувийг газрын тосны орлого, 46.6 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.4 хувийг түрээсийн орлого эзэлсэн бол 12.1 хувийг бусад орлого бүрдүүлж байна.



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 4,527.4 тэрбум төгрөг буюу 35.4 хувиар нэмэгдэж 17,318.2 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.



3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 21,561.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 80.3 хувийг зарлагдаж 4,243.6 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/

Тэрбум төгрөгөөр

Зардлын зүйл	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,570.0	12,254.1	6,727.2	3,529.4	3,392.2	3,310.5	1,469.1	1,445.7
НИЙТ ЗАРЛАГА	13,535.7	12,020.6	6,645.2	3,477.1	3,425.8	3,311.5	1,469.1	1,447.8
УРСГАЛ ЗАРДАЛ	11,484.4	10,162.1	2,916.0	1,982.7	3,425.8	3,311.5	1,469.1	1,447.8
Бараа, ажил, үйлчилгээний зардал	5,274.7	4,442.9	1,744.3	1,265.4	0.9	0.2	11.3	9.3
Зээлийн үйлчилгээний төлбөр	1,016.1	875.1	25.0	22.2	0.0	0.0	0.0	0.0
Татаас	1,397.0	1,318.1	244.9	206.3	0.0	0.0	0.0	0.0
Урсгал шилжүүлэг	3,796.6	3,526.0	901.8	488.7	3,424.9	3,311.4	1,457.8	1,438.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,051.3	1,858.5	3,729.1	1,494.4	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	34.3	233.5	82.0	52.3	-33.6	-1.0	0.0	-2.2
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-215.9	683.6	-2,242.1	565.8	403.6	413.8	-85.7	-90.9

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 1,315.9 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 3,197.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 81.7 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 23.4 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 35.4 хувь буюу 4,527.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд урсгал зардал 3,356.5 тэрбум, хөрөнгийн зардал 969.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.



Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 77.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 13.8 хувь буюу 143.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан байна.



Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл /зардлын эдийн засгийн ангиллаар/

Тэрбум төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	ӨО-ны мөн үе	2024 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,790.8	21,561.8	17,318.2	80.3	-4,243.6
НИЙТ ЗАРЛАГА	12,709.8	21,479.0	17,035.6	79.3	-4,443.5
УРСГАЛ ЗАРДАЛ	10,326.2	15,698.6	13,682.7	87.2	-2,015.9
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,751.1	6,668.5	5,386.3	80.8	-1,282.2
Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	1,344.3	3,572.7	3,287.7	92.0	-285.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216.8	335.6	277.3	82.6	-58.3
Хангамж, бараа материалын зардал	113.8	220.8	176.6	80.0	-44.2
Нормативт зардал	136.0	236.0	167.4	70.9	-68.6
Эд хогшил, урсгал засварын зардал	70.1	184.1	115.3	62.6	-68.8
Томилолт, зочны зардал	26.5	61.6	36.7	59.6	-24.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	527.3	1,118.7	676.7	60.5	-441.9
Бараа үйлчилгээний бусад зардал	316.2	939.2	648.4	69.0	-290.8
ХҮҮ	819.5	1,041.1	897.4	86.2	-143.7
ТАТААС	335.6	596.8	479.3	80.3	-117.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,420.1	7,392.2	6,919.7	93.6	-472.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,211.8	1,692.1	1,604.7	94.8	-87.4
Бусад урсгал шилжүүлэг	4,208.3	5,700.1	5,315.0	93.2	-385.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,383.5	5,780.4	3,352.9	58.0	-2,427.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	81.1	82.7	282.6	341.6	199.9

“**Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд урсгал зардлын эзлэх хувийн жин 80.4 хувьд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.2 пунктээр буурсан байна.**”


Эх сурвалж: Сангийн яам
Нэгдсэн төсвийн нийт зарлагын 79.0 хувь буюу 13,682.7 тэрбум төгрөг нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 50.6 хувийг урсгал шилжүүлэг, 39.3 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 6.6 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.5 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 3,356.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил үйлчилгээний зардал 2,635.2 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 77.9 тэрбум, татаас 143.7 тэрбум, урсгал шилжүүлэг 499.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

График 5. Урсгал зардлын бүтэц

/хувиар/

“**Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 39 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн нийт зарлага 1,315.9 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 90.3 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.**”



“**Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлагын 23.6 хувийг Сангийн сайдын багц, 18.2 хувийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц, 22.9 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 8.6 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 6.7 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, үлдэх 20.0 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал эзэлж байна.**”

Хүснэгт 6. Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Сая төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	2024 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	21,043.5	14,012.2	7,031.4	66.6
Монгол Улсын Их Хурлын дарга	84,414.9	59,033.3	25,381.6	69.9
Үндсэн хуулийн цэцийн дарга	2,666.6	2,482.0	184.6	93.1
Улсын дээд Шүүхийн ерөнхий шүүгч	11,711.8	8,921.9	2,789.9	76.2
Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн дарга	93,541.7	78,800.8	14,740.9	84.2
Улсын ерөнхий прокурор	70,021.1	60,751.2	9,269.9	86.8
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	15,278.3	14,025.4	1,252.9	91.8
Монгол Улсын Ерөнхий сайд	252,525.3	180,007.0	72,518.3	71.3
Монгол Улсын Шадар сайд /онцгой байдлын асуудал эрхэлсэн/	197,870.1	162,808.1	35,062.0	82.3
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	53,999.6	38,399.5	15,600.1	71.1
Сангийн сайд	3,249,238.1	2,892,149.5	357,088.7	89.0
Хууль зүй, дотоод хэргийн сайд	895,672.3	814,881.3	80,791.0	91.0
Байгаль орчин, уур амьсгалын өөрчсөлтийн сайд	145,969.5	104,423.2	41,546.4	71.5
Батлан хамгаалахын сайд	380,838.5	333,712.4	47,126.2	87.6
Боловсролын сайд	2,427,170.2	2,229,324.9	197,845.3	91.8
Гадаад харилцааны сайд	132,340.9	90,674.1	41,666.9	68.5
Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	27,417.0	21,918.8	5,498.2	79.9
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	415,288.4	349,911.2	65,377.1	84.3
Эрүүл мэндийн сайд	1,104,180.7	1,049,459.0	54,721.6	95.0
Төрийн албаны зөвлөлийн дарга	5,130.3	2,853.0	2,277.3	55.6
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	45,984.3	33,327.6	12,656.7	72.5
Хүний эрхийн үндэсний хорооны дарга	3,472.9	3,215.1	257.8	92.6
Монгол Улсын ерөнхий аудитор	26,641.8	23,340.6	3,301.2	87.6
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	9,549.4	6,815.3	2,734.1	71.4
Үндэсний Статистикийн хорооны дарга	14,259.6	12,516.6	1,743.0	87.8
ЦАУЗБУК-ын дарга	8,008.6	7,955.5	53.1	99.3
Зам, тээврийн сайд	212,714.0	198,612.2	14,101.7	93.4
Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд	111,448.4	106,106.9	5,341.6	95.2
Эрчим хүчний сайд	162,087.8	148,480.2	13,607.6	91.6
Авлигатай тэмцэх газар	34,979.4	25,867.7	9,111.8	74.0
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	281,769.6	254,463.5	27,306.0	90.3
Монгол Улсын Шадар сайд /өрсөлдөөний асуудал эрхэлсэн/	3,464.9	1,576.9	1,888.0	45.5
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	2,907,622.4	2,801,979.4	105,643.0	96.4
Монгол улсын сайд, хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга	10,391.3	3,548.1	6,843.2	34.1
Монгол улсын сайд, 20 минутын хот үндэсний хорооны дарга	27,931.2	27,931.2	0.0	100.0
Шүүхийн сахилгын хорооны дарга	2,974.6	2,404.7	569.9	80.8
Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд, эдийн засаг, хөгжлийн сайд	67,379.2	52,948.7	14,430.5	78.6
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	48,057.5	30,628.7	17,428.7	63.7
Монгол улсын сайд, боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга	4,985.8	3,855.1	1,130.7	77.3
НИЙТ ЗАРДАЛ	13,570,041.5	12,254,122.9	1,315,918.6	90.3

Эх сурвалж: Сангийн яам

2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 885.4 тэрбум төгрөгийг зарцуулж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2024 онд нийт 3,359.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 885.4 тэрбум төгрөгийг зарцуулж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл
/Төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Сая төгрөгөөр


Хуулийн дугаар	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	2024 оны төсөв	2024 оны эхний 8 сарын гүйцэтгэл			
			Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
I	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	22,089.6	10,129.7	10,129.7	0.0	100.0
II	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	1,200.0	234.0	234.0	0.0	100.0
III	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	25,687.7	6,951.2	6,951.2	0.0	100.0
IV	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	44,000.0	1,403.4	1,403.4	0.0	100.0
V	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	51,391.4	9,146.8	9,146.8	0.0	100.0
VI	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧСӨЛТИЙН САЙД	36,937.3	3,331.5	3,331.5	0.0	100.0
VII	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	20,015.3	6,838.9	6,838.9	0.0	100.0
VIII	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	13,700.0	10,178.7	10,178.7	0.0	100.0
IX	САНГИЙН САЙД	224,776.2	30,907.1	30,907.1	0.0	100.0
X	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	127,187.7	62,462.8	62,384.5	78.3	99.9
XI	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	48,758.1	14,613.0	14,613.0	0.0	100.0
XII	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	405,293.0	99,186.7	99,186.7	0.0	100.0
XIII	БОЛОВСРОЛЫН САЙД	744,870.7	203,339.3	203,339.2	0.1	100.0
XIV	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	154,881.0	35,566.5	35,566.5	0.0	100.0
XV	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	612,006.5	154,352.4	154,352.4	0.0	100.0
XVI	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	123,588.3	31,901.6	31,901.6	0.0	100.0
XVII	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	224,286.0	71,738.1	71,738.1	0.0	100.0
XVIII	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	281,079.0	74,110.0	74,110.0	0.0	100.0
XIX	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	2,658.2	1,504.1	1,504.1	0.0	100.0
XX	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	11,528.8	-	-	0.0	-
XXI	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ	19,825.0	-	-	0.0	-
XXII	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	11,348.3	7,995.3	7,995.3	0.0	100.0
XXIII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	881.1	-	-	0.0	-
XXIV	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	892.5	-	-	0.0	-
XXV	ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	16,423.0	339.6	339.6	0.0	100.0
XXVI	МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	72,353.4	20,181.1	20,181.1	0.0	100.0
XXVII	МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	5,463.1	1,137.0	1,137.0	0.0	100.0
XXVIII	"МОНГОЛ УЛСЫН САЙД, НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТОЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА"	56,229.2	27,931.2	27,931.2	0.0	100.0
	НИЙТ	3,359,350.2	885,480.0	885,401.6	78.4	100.0

Эх сурвалж: Сангийн яам



5. Нийгмийн даатгалын сан

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

/Тэрбум төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН




↑ -Өөрчлөлт (Өнгөрсөн оны мөн үеэс)

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 3,310.5 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 779.6 тэрбум төгрөг буюу 30.8 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн даатгалын сангийн зарлага 734.6 тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 20.7 тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 1.3 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 13.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 3,724.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 1.9 хувь буюу 71.4 тэрбум төгрөгөөр дутуу биелэн орлогын гүйцэтгэл 63.2 хувьтай гарсан байна.


График 6. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын бүтэц /Хувиар/



6. Эрүүл мэндийн даатгалын сан

“
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 2.1 хувиар дутуу биелжээ.
”


График 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/



Эрүүл мэндийн даатгалын санд 2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 1,354.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 2.1 хувь буюу 28.7 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

“
Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,469.1 тэрбум төгрөгийн зарлага хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 368.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.
”

График 8. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 1,469.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, 1,445.7 тэрбум төгрөгийг зарцуулж, тус сангийн гүйцэтгэл 98.4 хувьтай гарчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 368.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 3,197.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

7. Орон нутгийн төсөв

2024 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 4,095.2 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 8.7 хувь буюу 389.9 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол орон нутгийн төсвийн нийт зарлага 3,529.4 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 47.5 хувь буюу 3,197.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, орон нутгийн төсвийн тэнцэл 565.8 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 50.3 хувь буюу 1,371.4 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт зарлага 86.4 хувиар буюу 1,635.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 85.8 хувийг орон нутгийн төсвийн орлого, 7.0 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг 7.2 хувийг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 285.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөгдөж 100 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт 8. Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг


Сая төгрөгөөр

АЙМАГ	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	26,692.3	26,692.3	100.0	7,666.2	7,549.5	98.5
Баян-Өлгий	17,173.9	17,173.9	100.0	7,143.0	7,055.9	98.8
Баянхонгор	27,614.4	27,614.4	100.0	12,579.6	12,359.9	98.3
Булган	7,380.3	7,380.3	100.0	8,456.2	8,375.2	99.0
Говь-Алтай	23,942.1	23,942.1	100.0	10,098.8	9,976.2	98.8
Дорноговь	0.0	0.0	0.0	25,302.3	24,304.5	96.1
Дорнод	0.0	0.0	0.0	15,407.2	14,685.1	95.3
Дундговь	18,027.3	18,027.3	100.0	9,065.7	8,980.0	99.1
Завхан	25,262.2	25,262.2	100.0	8,813.4	8,708.5	98.8
Өвөрхангай	22,047.0	22,047.0	100.0	8,711.6	8,556.9	98.2
Өмнөговь	0.0	0.0	0.0	27,866.2	27,322.6	98.0
Сүхбаатар	8,876.8	8,876.8	100.0	10,852.8	10,757.2	99.1
Сэлэнгэ	0.0	0.0	0.0	16,683.4	16,512.6	99.0
Төв	13,161.1	13,161.1	100.0	16,774.9	16,675.6	99.4
Увс	22,762.8	22,762.8	100.0	7,837.4	7,705.7	98.3
Ховд	10,009.8	10,009.8	100.0	17,728.6	17,617.2	99.4
Хөвсгөл	30,078.0	30,078.0	100.0	10,151.6	10,016.6	98.7
Хэнтий	27,188.3	27,188.3	100.0	11,035.9	10,930.5	99.0
Дархан-Уул	0.0	0.0	0.0	12,596.1	12,527.2	99.5
Улаанбаатар	0.0	0.0	0.0	30,391.7	30,008.2	98.7
Орхон	0.0	0.0	0.0	21,021.1	20,952.9	99.7
Говьсүмбэр	4,925.7	4,925.7	100.0	4,207.2	4,161.4	98.9
ДҮН	285,141.9	285,141.9	100.0	300,391.0	295,739.2	98.5

Эх сурвалж: Сангийн яам

Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 389.9 тэрбум төгрөг буюу 8.7 хувиар дутуу төвлөрсөн нь орон нутгийн орлого 9.9 хувь буюу 368.0 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөнтэй шууд холбоотой байна.

График 9. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал: Дорноговь аймаг 12,487.0 сая, Дорнод аймаг 9,724.3 сая, Өмнөговь аймаг 229,731.6 сая, Сүхбаатар аймаг 8,943.7 сая, Улаанбаатар хот 196,080.3 сая, Орхон аймаг 27,283.2 сая төгрөгөөр төлөвлөгөөг дутуу биелүүлсэн бол Архангай аймаг 4,882.3 сая, Баян-Өлгий аймаг 2,275.7 сая, Баянхонгор аймаг 1,210.1 сая, Булган аймаг 12,085.2 сая, Говь-Алтай аймаг 2,213.1 сая, Дундговь аймаг 3,545.5 сая, Завхан аймаг 8,956.0 сая, Өвөрхангай аймаг 5,428.3 сая, Сэлэнгэ аймаг 5,558.9 сая, Төв аймаг 11,849.0 сая, Увс аймаг 6,166.1 сая, Ховд аймаг 6,357.8 сая, Хөвсгөл аймаг 9,876.1 сая, Хэнтий аймаг 5,744.8 сая, Дархан-Уул аймаг 10,890.0 сая, Говьсүмбэр аймаг 1,988.1 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс илүү төвлөрүүлсэн байна.